



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№74 /518/

2023.05.08

Цаг үе, үйл явдал

Г.Сайханбаяр: АМРАЛТЫН ӨДӨР БОЛСОН ЖАГСААЛД МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ОРОЛЦОО ОГТ БАЙХГҮЙ



өдөр дайнд амиа өргөсөн дайчдын алдрыг мөнхжүүлэх зорилгоор жагсаал хийх гэж байгаа тул хүч, хөгжим хэрэгслээр дэмжлэг туслалцаа үзүүлж өгнө үү хэмээх хүсэлтийг Батлан хамгаалах яаманд хүргүүлсэн. Бид бүхэн уг хүсэлтийг хэлэлцээд дэлхийн улс орнуудын цэрэг-улс төрийн байдал тогтворгүй байгаа энэ цаг үед дайн, байлдаантай холбоотой арга хэмжээ, жагсаал цуглаанд Монгол Улсын Батлан хамгаалах яам ямарваа нэг байдлаар оролцох нь зохимжгүй гэсэн дүгнэлтэд хүрч оролцохоос татгалзсан. Гэтэл үүнд ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн бие бүрэлдэхүүн оролцсон гэсэн мэдээллүүд цахим орчинд тархсан. Энэ бол худал мэдээ. Зэвсэгт хүчний анги, салбарт байгаа цэргийн хөгжим, бие бүрэлдэхүүн оролцоогүй.

Мөн энэ сарын 7-ны өдөр Офицеруудын ордны үүдэнд "Новороссия андууд" хэмээх олон нийтийн сайн дурын байгууллага жагсаал зохион байгуулж үүнд нь бэлтгэл болон чөлөөнд байгаа цөөн тооны офицер, ахлагч оролцсон. Эдгээр байгууллагуудын хувьд "сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн олон нийтийн гэх статустай байгууллага. Энэ бол Төрийн байгууллага биш. Түүнчлэн жагсаалд оролцсон зарим цэргийн алба хаагчдын хувьд төрийн бус байгууллагын гишүүнчлэлтэй тэтгэвэр, чөлөөндөө гарсан алба хаагчид оролцсон гэдгийг хэлье.

Гадаад харилцаа, аюулгүй байдлын нөхцөл байдал амаргүй сорилттой тулгарч буй энэ цаг үед ард иргэд маань энэ төрлийн асуудалд болгоомжтой, бас мэдрэмжтэй хандаасай гэж хүсэж байна. Зарим нэр нөлөө бүхий олны танил хүмүүс ч Батлан хамгаалах яам оролцсон гэх мэтээр ташаа мэдээлэл тараахгүй байхыг хүсье" хэмээсэн юм.

Өнгөрсөн амралтын өдрүүдэд ОХУ-ыг дэмжсэн жагсаалууд болсон. Уг жагсаалыг Монгол Улсын Засгийн газар тэр дундаа Батлан хамгаалах яам дэмжсэн гэх мэдээлэл цахим орчинд тархаад байв. Тэгвэл энэ талаар Батлан

хамгаалахын сайд Г.Сайханбаяр тайлбар хийж албан ёсны байр сууриа илэрхийллээ.

Тэрбээр хэвлэл мэдээллийнхэнд өгсөн тайлбартаа "олон нийтийн гэх тодотголтой байгууллагын төлөөлөл энэ сарын 5-ны

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	☁️ 0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,461	3,467
EUR 🇪🇺	3,842	3,855
CNY 🇨🇳	503	504.50
RUB 🇷🇺	43	43.70
JPY 🇯🇵	25.75	25.95
KRW 🇰🇷	2.64	2.66

ЗУРХАЙ



2023.05.08 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 18

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ УЛААН БАР ӨДӨР

Үс засуулбал:

Эд малын гарлагатай
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.35-20.04
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Хуран үйлдэхүй

АЖЛЫН ХЭСЭГ ХУРАЛДАВ



Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралаар ахлуулсан бүх яамдын Төрийн нарийн бичгийн дарга нарын хамтарсан ажлын хэсэг өнгөрсөн пүрэв гарагт Төрийн ордонд хуралдлаа.

Төрийн байгууллагуудад хэрэгжүүлж байгаа цахим төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, дижитал эдийн засгийг хөгжүүлэх,

цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий уг ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан юм.

Хурлын эхэнд ЦХХХ-ны сайд Н.Учрал Төрийн нарийн бичгийн дарга нарт болон холбогдох ажил хариуцсан хүмүүст авлигын эсрэг 5Ш

ажиллагаа, Шилэн ажиллагааны хүрээнд бий болсон shilen.gov.mn платформд салбар бүрийн мэдээлэл хариуцагч нараас ирүүлж буй нээлттэй мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэт байх эсэхэд анхаарал хандуулж, нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг чиглэл болголоо.

Мөн төрийн албаны зардал, хүнд суртлын нэг шалтгаан болсон албан бичиг солилцоог цахимаар зохион байгуулах, Монгол Улсын Засгийн газраас өгсөн үүргийн дагуу төрийн албан бичиг солилцооны дундын системийн ашиглалтыг төрийн албан хаагчдад хэвшүүлэх асуудлыг хэлэлцлээ.

Ингэснээр цахим шийдэл ашиглан төрийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, хурдан шуурхай зохион байгуулах, зардал хэмнэх зэрэг давуу талууд бодитоор үүсэх юм.

Төрийн нарийн бичгийн дарга нарын хамтарсан ажлын хэсгийн хуралдаанаар орон нутаг дахь мэдээлэл технологийн боловсон хүчний хомсдолтой, хүртээмжгүй байдлыг олон жилийн

туршлагатай, төрийн өмчийн оролцоотой, боловсон хүчний нөөц, сургалтын бааз, суурьтай "Монголын цахилгаан холбоо" ХК нэгдсэн байдлаар хариуцах боломжтой талаар танилцууллаа.

Шилэн ажиллагааны хүрээнд төрийн мэдээллийг нээлттэй, ил тод болгох асуудалд зарим нэг хуулийн зохицуулалтыг эргэж харах шаардлагатай байгааг төрийн нарийн бичгийн дарга нар мөн хэлж байлаа. Жишээ нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийг эргэж харж мэдээллийг ил тод болгоход зөрчилдөж байгаа зарим зохицуулалтуудыг шинэчлэх шаардлага үүссэн байна гэв.

Мөн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын үйл ажиллагааг төрийн нарийн бичгийн дарга нарт болон холбогдох ажил хариуцсан хүмүүст танилцууллаа. Төрийн үйлчилгээг иргэдэд ойрхон хүргэж, хүнд суртал, зардал чирэгдэл бууруулах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн тухай мэдээлэл өгч уялдаа холбоог хангахад хамтарч ажиллахаар тохиролцлоо.

ХОШУУЧ БАРИУНЖАРГАЛЫГ ОНЦОЛЖЭЭ



НҮБ-аас өнөөдрийн онцлох энхийг сахиулагчаар Монгол Улсаас Баруун сахарт алба хааж буй цэргийн ажиглагч хошууч Б.Ариунжаргалыг онцолж байна.

Тэрээр, "Энх тайван бол амьд бөгөөд түгээн дэлгэрүүлж, хайрлан хамгаалж байх үнэт зүйл юм" хэмээжээ.

UN PEACEKEEPING



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 687,819,180

Эдгэрсэн

Нийт: 660,274,766

Нас барсан

Нийт: 6,871,104

Цахим шууданд

АЗИЙН АВАРГААС 11 АЛТ, 11 МӨНГӨ, 4 ХҮРЭЛ МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ



Киргизстан Улсын Бишкек хотод 5 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд Ази тивийн аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээн амжилттай явагдаж өндөрлөлөө.

Монгол Улсаас 14 тамирчин оролцсон нь Зэвсэгт хүчний 029, 150, 232, 330 дугаар ангиудын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч, сонсогч байсан бөгөөд тэд 11 алт, 11 мөнгө, 4 хүрэл нийт 26 медаль хүртсэн бахдам амжилт үзүүлж, эх орон, Зэвсэгт хүчнээ тэмцээнд оролцогч 8 орны 400 гаруй тамирчинд сурталчиллаа.

Тэмцээний сүүлийн өдөр буюу өчигдөр манай алба хаагчдаас "U23" өсвөр насны ангиллын 78 кг жинд ахлах түүрүүч О.Золбаяр (150) огцом өргөлтөөр алт, насанд хүргэгчдийн ангиллын 95 кг жинд ахлагч Э.Ирээдүй (330) огцом өргөлтөөр алт, тус жинд ахлах ахлагч Б.Найдансүрэн (150) хүрэл медаль хүртэв. Мөн "U35-39" насанд хүрэгчдийнэмэгтэйчүүдийнангилалд -68 кг жинд сургагч ахлагч П.Ганзаяа (232) огцом өргөлтөөр алт, +68 кг жинд ахлах дэслэгч С.Ууганцэнгэл (330) огцом өргөлтөөр алтан медаль

тус тус хүртэж, амжилтын буухиагаа үргэлжлүүллээ. Ингэснээр ахлах дэслэгч С.Ууганцэнгэл, сургагч ахлагч П.Ганзаяа нар туухай өргөлтөөр Азийн хошой аварга болсон бол цэргийн гэрээт алба хаагч ахлах түүрүүч О.Золбаяр нэг алт, гурван мөнгөн медалийн эзэн болж чадсан гэсэн үг юм.

Тэмцээний амжилтын талаар багийн дасгалжуулагч ахлах ахлагч Л.Билэгтбаатар (150) ярихдаа "Үнэхээр баяртай байна. Манай тамирчид 26 медалийг хүртэж, монгол хүн тэр дундаа монгол цэрэг ямар хүчтэй, нөөц бололцоо ихтэй байдгийг батлан харуулсандаа баяртай байна. Дэлхийн 8 орны 400 гаруй тамирчин оролцож байгаа энэ том тэмцээнээс бүх төрөлд нь медаль хүртэнэ гэдэг бол бахархам биз.

Тэмцээний хаалтын ёслолын үеэр Олон улсын гийрийн спортын зөвлөлийн ерөнхийлөгч Солодов Игорь Петрович монгол тамирчдын амжилтад баяр хүргэж, 2023 оны 9 дүгээр сард Узбекистан Улсад зохион байгуулагдах Дэлхийн аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээнд оролцохыг албан ёсоор

урьсан.

Мөн 2024 оны Азийн аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээнийг Монгол Улс зохион байгуулах тухай санал дэвшүүлж, харилцан ярилцсан. Энэ талаар бид бүхэн холбогдох байгууллага, холбоодод нь уламжилна.

Энэ завшаанд талархал илэрхийлэх ёстой хүмүүс байна. Баг тамирчдыг маань тэмцээнд оролцох асуудлыг зохицуулж шийдвэрлэсэн ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ болон Монгол Улсад Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, хурандаа Б.Дамба даргад талархал илэрхийлье. Хурандаа Б.Дамба "Өөрсдийгөө л сайн бэлтгээд ир, бусдыг нь дарга нь зохицуулна. Та бүхнийг манай цэргийн найз Киргизстан улсад тосож аваад дэмжлэг үзүүлнэ" гэсэн, үнэхээр л цэргийн найз нь тусалсан. 1990 онд ЦНДС-ийг Ерөнхий цэргийн командын офицер мэргэжлээр төгссөн бэлтгэл офицер Д.Баясгалан ах гэр бүлийнхээ хамтаар бидэнд бүх талын дэмжлэг үзүүлсэнд нь талархаад баршгүй. Ёстой нөгөө тэмцээн болох газраа ч мэдэхгүй бидэнд замч хийж "Монгол цэргийн нэр хүндийг өргөж байвал бусад нь болно оо" гээд л тамирчин бүрийн ялалт, ялагдалтай хамт байлаа" хэмээн баярласнаа илэрхийлж, амжилтын богц дүүрэн эх орныхоо зүг хөдөлж байгаагаа дуулгалаа.

Ахмад Д.БОЛОР

"АСТАНА-2023" АЗИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН...



Казахстан Улсын Астана хотод зохиогдож буй "АСТАНА-2023" Азийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн эмэгтэйчүүдийн төрөлд "Алдар" спорт хорооны тамирчин Ч.Отгонтуяа 55кг жинд мөнгөн медаль, МУГТ П.Орхон 62кг жинд мөнгөн медаль,

ОУХМ Э.Даваанасан 72кг жинд хүрэл медаль тус тус хүртлээ. Ийнхүү Астанагийн дэвжээнд "Алдар" спорт хорооны эмэгтэй тамирчид 2 мөнгө, 1 хүрэл медальтай тэмцээнээ өндөрлүүллээ.



Зарлал

АЛДАР СПОРТ ХОРООНЫ ҮНДЭСНИЙ БӨХИЙН СУРГАЛТ



ШИНЭ ЭЛСЭЛТ

16-ААС ДЭЭШ НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙГ ШАЛГАРУУЛЖ АВНА.

04-Р САРЫН 10 ХИЧЭЭЛЛЭЖ ЭХЭЛНЭ.

БЗД, Офицеруудын ордоны чанх ард Алдар спорт хороо
 Алдар спорт хороо
 91911644

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
 Утас: 70001029, 3412 (дотуур)

ХИЛЧИН ДАЙЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Монгол Улсын бүрэн бүтэн байдлыг Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, эх орныхоо халдашгүй дархан байдал, эрх чөлөө, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн


ээлжээр Баянзүрх дүүргээс цэргийн албанд татагдаж, албаа нэр төртэй хаасан хилчин залуусаа Нийслэлийн Баянзүрх дүүргийн удирдлага хүлээн авч, хүндэтгэл үзүүлээ. Хүндэтгэлийн ажиллагаанд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын орлогч Г.Жаргалсайхан, Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга дэд хурандаа Л.Гантогтох нар болон хилчин дайчдын ар гэр, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцлоо.

Б а я н з ү р х дүүргийн Засаг даргын орлогч Г.Жаргалсайхан

хүндэтгэлийн ажиллагааны үеэр эх орон, ард түмнийхээ итгэлийг өргөн, цэргийн албаа үлгэр жишээчээр хаасанд залуустаа баяр хүргэн, цаашид ажиллаж хөдөлмөрлөх үйлсэд нь дүүргийн удирдлагын зүгээс дэмжин ажиллахаа илэрхийлсэн юм.

Энэ үеэр ЦДБЭЧ-ын гоцлол уран бүтээлчид цэрэг-эх орны сэдэвт "Торгон хилийн зүг", "Байлдагчийн дуу", "Халагдах цэргийн вальс" хэмээх дуунуудаар эрхэм хүндэтгэлийн эзэд болсон залуучууддаа мэндчилгээгээ өргөн барьсан юм.

АНХНЫ ТЭРГҮҮН АХЛАГЧ ЭМЭГТЭЙ АНХНЫ ДОКТОР АХЛАГЧ БОЛЛОО



Та бүхэнд уйгагүй хөдөлмөрч, анхдагчийг бүтээгч цэргийн нэгэн бүсгүйг танилцуулах гэж байна. Өнөө үед Зэвсэгт хүчний нийт бүрэлдэхүүний дийлэнх олонхыг ахлагчийн алба бүрдүүлж байгаа билээ. Тэгвэл ахлагчийн алба дотроо тэргүүн ахлагч цол хүртсэн цор

ганц мөрдэстэй эмэгтэй байдаг нь ҮБХИС-ийн Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Сургалтын албаны ахлах мэргэжилтэн Цэрэнжамцын Оюунчимэг.

Өдгөөгөөс 6 жилийн өмнө буюу 2017 онд тэргүүн ахлагч цол хүртэж "Анхны эмэгтэй тэргүүн ахлагч" хэмээх алдрыг бүтээж байсан тэрээр гайхалтай нь саяхан дахин анхдагч болж чадлаа. Тэр юу гэхээр "Монгол Улсын Зэвсэгт хүчний ахлагч бэлтгэх сургалт, түүнийг боловсронгуй болгох арга зам" сэдвээр цэргийн сургалт, судлал мэргэжлээр цэргийн ухааны доктор (Ph.D) зэрэг хамгаалсан бөгөөд ахлагчийн албанаас төрсөн анхны цэргийн эрдэмтэн нь тэр болов.

Тасралтгүй хөдөлмөрлөж, шантралгүй суралцаж, эргэлт

буцалтгүйгээр өөрийгөө дайчилж яваа тэрээр ийнхүү хоёр анхдагч түүхийн эзэн болсон нь уйгагүй хичээл зүтгэл бүрийн ард амжилт байдгийг батлан харуулжээ.

Тэргүүн ахлагч Ц.Оюунчимэг нь 2001 онд Зэвсэгт хүчний 150 дугаар ангиас ажлын гараагаа эхлүүлж, 2002 онд АНУ-д Удирдлагын шатны дамжаанд явсан анхны таван ахлагчийн нэг билээ.

Тэрээр цэргийн хүний гэргий бөгөөд түүний хань хурандаа Г.Ялалт нь цэрэг армийг ардиргэдтэй холбох, төр захиргааг ард түмэнтэй холбох, цэргийн үүрэгтнүүдийг эх оронд нь дуудах, эх оронч үзэл хүмүүжлийг түгээх зэрэг хамгийн цаг наргүй ажил албыг хашдаг офицер юм. Хамтдаа эх орныхоо төлөө зүтгэж, хамтдаа дахин давтагдашгүй түүх бүтээж байгаагийн цаана нэр хөдөлмөр, нэр их хичээл зүтгэл нуугдаж байгаа биз ээ...

Дарга дэд хурандаа
САЙНБОЛДЫН УУГАНБААР

ЦАХИМ ХАЯГ
 Батлан хамгаалах яам
 Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
 "Соёмбо" редакц
 "Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
 * Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
 * Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
 Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
 Утас: 70001029, 3412 (дотуур)